



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/42

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгаас хөнгөлөлттэй үнээр ирсэн 800 боодол өвсийн үнэ 6,400,000 (зургаан сая дөрвөн зуун мянга) төгрөг, 1000 шуудай улаан буудайны үнэ 8,000,000 (найман сая) төгрөг, Улсын онцгой комиссоос үнэгүй өгсөн 306 шуудай 50 кг гурил, 306 шуудай 25 кг будаа тээвэрлэлтийн зардалд 1,700,000 (нэг сая долоон зуун мянга), 23 тн улаан буудай тээвэрлэлтийн зардалд 4,000,000 (дөрвөн сая) төгрөг, нийт 20,100,000 (хорин сая нэг зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 20,100,000 (хорин сая нэг зуун мянга) төгрөгийг сумын Эрсдэлээс хамгаалах сангаас зарцуулахыг сумын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

